



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 192

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.4, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Булган аймгийн Прокурорын газрын 2013 оны 5/108 дугаар прокурорын тогтоолд зааснаар осол гарахад гэм буруутай нь тогтоогдсон иргэн нас барсны улмаас хэргийг хэрэгсэхгүй болгосон тул Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, сэргээн засварлах боломжгүй болсон нийт 16,236,000.00 /арван зургаан сая хоёр зуун гучин зургаан мянган/ төгрөгийн балансын үнэ бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Я.Амаржаргал, Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирал Э.Хүдэрчулуун нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Акталж, данснаас хасаж буй автомашины улсын дугаарыг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, дээрх арга хэмжээний биелэлтийн хамт 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА



3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭЧ

Д.НАРАНГЭРЭЛ

000352

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн  
132 дугаар тогтоолын хавсралт



Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо,  
эмчилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй  
акталж, данснаас хасах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	УАЗ-22069 маркийн 17-59 ΘВА, арал №90495880	2009/ 2009	16,236,000.00	16,236,000.00
	Нийт дүн		16,236,000.00 /арван зургаан сая хоёр зуун гучин зургаан мянган/	16,236,000.00 /арван зургаан сая хоёр зуун гучин зургаан мянган/